

“Энэ бүх бэлэг Бурханаас ирдэг”

Сургаал ба Гэрээ 46:13–26-г уншаад, Бурханы хүүхдүүддээ өгдөг олон сүнслэг бэлгийг тодорхойл. Эдгээр бэлэг Бурханы хүүхдүүдэд хэрхэн ач тустай болохыг илүү сайн ойлгоход нь туслахын тулд шүлэг болгоныг тохирох жишээнүүдтэй холбо.

| Сүнслэг бэлгүүд | |
|-------------------------------|--|
| 1. Сургаал ба Гэрээ 46:13 | А.Мишээл Залуу эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа ангийн гишүүдийнхээ өөр өөр давуу талыг ялган таньж чаджээ. Ийн ялган таньсан нь ангийнханд утга учиртай арга замаар хувь нэмрээ оруулж, үйлчлэх боломжийг олгох томилгоонуудыг хийхэд түүнд тусалжээ. |
| 2. Сургаал ба Гэрээ 46:14 | В.Саманта бусдын гэрчлэлийг сонсож байхдаа Сүм үнэн гэдгийг мэднэ гэдгээ тэдний нэгэн адил хэлж чадах эсэхдээ итгэлгүй байв. Гэхдээ тэдний гэрчлэлийг сонссоноор Аврагчид итгэх итгэл нь нэмэгджээ. Энэ итгэл нь түүнийг итгэлээрээ үргэлжлүүлэн амьдрахад сүнслэгээр өдөөв. |
| 3. Сургаал ба Гэрээ 46:15 | С.Люсийг үдэшлэгт урьжээ. Хэн ч түүнд нарийн ширийн юм хэлээгүй ч түүнд тэнд оролцох талаар таагүй мэдрэмж төрөв. Тэр урилгаас эелдгээр татгалзлаа. Ингэх нь хэцүү санагдсан ч тэр зөв зүйл хийж байгаагаа мэдрэв. |
| 4. Сургаал ба Гэрээ 46:16 | Д.Их Эзэн олон бошиглогчид Есүс Христийн тохинуулал (Исаиа 7:14; 1 Нифай 11:27–28; Мозая 3:5–10-ыг үзнэ үү) гэх мэт ирээдүйд болох үйл явдлыг урьдчилж хэлэхэд тусалсан. |
| 5. Сургаал ба Гэрээ 46:17–18 | Е.Робэрт сайн мэдээний дагуу амьдарч, тогтмол залбирч, судраас судлахыг хичээснээр Есүс Христ бол түүний Аврагч гэдгийг мэддэг болсон. |
| 6. Сургаал ба Гэрээ 46:19–20 | Ү.Ахлагч Васкүз, ахлагч Кокс хоёрт номлолын ажил хүнд байсан ч тэд Есүс Христэд итгэлтэйгээр үйлчлэхээр шийджээ. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд зүрх сэтгэл нь зөөлөрч, зааж байгаа хүмүүсийнх нь амьдралд гайхамшгууд тохиож байгааг харж эхлэв. |
| 7. Сургаал ба Гэрээ 46:21 | Г.Марк өвдөхдөө ааваасаа санваарын адислал авч болно гэдгээ мэддэг. Олон удаа эдгээр адислал нь түүнд илүү их амар амгалан, хүч чадлыг өгч байжээ. |
| 8. Сургаал ба Гэрээ 46:22 | Н.Сошиал медиа дээрх нэг нийтлэл Алисын нэг найзыг итгэлдээ эргэлзэхэд хүргэв. Уг нийтлэлийг Алистай хуваалцахад тэр тухайн мэдээлэл Бурханаас биш болохыг ялган таньсан. |
| 9. Сургаал ба Гэрээ 46:23 | И.Жудигээс Залуу эмэгтэйчүүдийн ангид заахыг хүсэв. Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг эрэлхийлснээр тэр хичээлдээ бэлтгэхдээ удирдамж хүлээн авч, сэнхрүүлэх хичээл зааж чаджээ. |
| 10. Сургаал ба Гэрээ 46:24–25 | Ј.Эриксон эгч өөр улсад номлолд үйлчлэхээр дуудагдав. Тэрээр Бурханаас тусламж эрэлхийлж, хэлээ сурахаар ажилласнаар бусдыг ойлгож, хүчирхэг гэрчлэл хуваалцаж чадаж байгаагаа олж мэдэв. |